



ГЛОБ ИНТЕРНЭШНЛ

СОНИН БИЧИГ

Дугаар 6 2006 оны 10 сар

www.globeinter.org.mn, www.monitoring.mn



ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТББ

Энэхүү сонин бичгийг “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн мониторинг ба хараат бус хэвлэл мэдээллийн эрхийг дэмжих нь” төслийн хүрээнд “Глоб Интернэшнл” ТББ-аас 2 сар тутамд эрхлэн гаргана.

Энэ дугаарт

Мониторингийн явц

Сэтгүүлчийн эрхийн зөрчил ба үйлдэл

Хоёрдугаар нүүр

Өвөөгийн жор

Ерөөлийн үг

Гурав, дөрөвдүгээр нүүр

Хуульч зөвлөж байна

Сэтгүүлч ба эрх зүй

Тавдугаар нүүр

Тэд асууж байна

Сэтгүүлчийн үйл ажиллагаанд саад тотгор учирвал

Зургадугаар нүүр

Шинэ чиг хандлага

Иргэнийн сэтгүүл зүй

Долдугаар нүүр

Далайд дусал

Олон нийтийн эсэргүүцлийн үйл ажиллагааг хэрхэн зөв зохион байгуулах вэ?

Наймдугаар нүүр

Сонин бичгийг онлайн болон хэвлэмэл хэлбэрээр авч унших сонирхолтой хүмүүс дараах хаягаар холбоо барина уу.

Манай хаяг: Соёлын төв өргөө, Г корпус, 3 давхар, Улаанбаатар 210620-А, Ш/х-28

Утас: Э-шуудан
324627 globe@magicnet.mn
324764 globe@globeinter.org.mn
99276253 garav@globeinter.org.mn
bayan@magicnet.mn

Редакцийн зөвлөл:

- Д.Мөнхбүрэн
- Г.Нарангараг
- Х.Цэвэлээ

Мэдээ ♦ Мэдээ ♦ Мэдээ

ОНРТ-ийн МОНИТОРИНГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛОВ

“Глоб Интернэшнл” ТББ 10-р сарын 20-нд “Олон нийтийн радио, телевиз мониторингийн тайланг”-ийн нээлттэй хэлэлцүүлгийг Хэвлэлийн Хүрээлэнд зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт телевизийн сэтгүүлч, МОУНРТ-ийн хамт олон болон Үндэсний Зөвлөлийн /ҮЗ/ гишүүд, ННФорум, МСНЭ-ийн төлөөлөгчид 20 орчим хүн оролцож, тайлангийн талаар өөрсдийн байр сууриа илэрхийлэв.

Дэлгэрэнгүй: <http://www.monitoring.mn/?module=record2&id=147&menuid=3>

СЭТГҮҮЛЧИЙН ЭРХ ЧӨЛӨӨНД ХАЛДЖЭЭ

Дархан-Уул аймгийн “7 хоног Дархан” сонины сурвалжлагч Т.Баясгалан 2006 оны 9-р сарын 28-нд Дархан сумын төв захад самрын хууль бус наймааны талаар сурвалжлага хийх үедээ “Тун” хоршооны ажилчин В.Сандагдоржоос самар зарах зөвшөөрөлтэй эсэхийг нь лавласан байна. Үүний дараа В.Сандагдорж сурвалжлагчийн гарыг 20 минут орчим ард нь барьж, мушгин эрх чөлөөнд нь халдсанаас гадна мэдээлэл авах эрхийг нь зөрчсөн байна.

Дэлгэрэнгүй: <http://www.globeinter.org.mn/newsdetail.php?nid=350>НУУЦЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТАЛААР
САНАЛ СОЛИЛЦОВ

“Глоб Интернэшнл” ТББ 9-р сарын 28-нд “Төрийн нууц ба мэдээллийн эрх чөлөө” сэдэвт олон нийтийн хэлэлцүүлгийг Хууль Зүйн Үндэсний төвд зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт хэвлэл мэдээлэл, ТТГ, Үндэсний Архивын газар, СЭЗЯ, ХЗДХЯ, ЦЕГ, Зэвсэгт хүчний жанжин штаб зэрэг байгууллагын нийт 40 гаруй хүн оролцож Төрийн нууцын тухай, мөн уг хуулийг шинэчлэх хэрэгцээ шаардлагын талаар өөрсдийн байр сууриа илэрхийлсэн байна.

Дэлгэрэнгүй: <http://www.globeinter.org.mn/newsdetail.php?nid=343>СЭТГҮҮЛЧИЙН ЭРХИЙН ЗӨРЧЛИЙГ ТАНИЛЦУУЛАХ ХЭВЛЭЛИЙН БАГА
ХУРАЛ БОЛОВ

“Глоб Интернэшнл” ТББ “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн мониторинг ба хараат бус хэвлэл мэдээллийг дэмжих нь” төслийн хүрээнд бүтгэсэн сэтгүүлчийн эрхийн зөрчлийг танилцуулах хэвлэлийн бага хурлыг 2006 оны 09-р сарын 22-нд Хэвлэлийн Хүрээлэнд зохион байгууллаа. Сэтгүүлчид эрх нь зөрчигдсөн тохиолдолд манай хуульдаас үнэгүй зөвлөгөө авах буюу бүсийн мониторингчид шууд мэдээлэх, эсвэл цаг зав байхгүй бол www.monitoring.mn сайтын хуулийн буланд холбогдох асуултаа тавьж хариулт авах боломжтой тухай “Глоб Интернэшнл” ТББ-ын тэргүүн Х.Наранжаргал онцлон тэмдэглэв.

Дэлгэрэнгүй: <http://www.globeinter.org.mn/newsdetail.php?nid=340>

ЗАЛУУЧУУД СУТАЙ ХАЙРХАН УУЛАНД АМЖИЛТТАЙ АВИРАВ

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жил, Монгол Улсад Залуучуудын байгууллага, хөдөлгөөн үүсэж хөгжсөний 85 жилийн ойн хүрээнд Завхан аймгийн Уул, аяллын холбоо, Залуучуудын холбооноос санаачлан тус аймгийн уулчид 2006.08.13-17-ний өдрүүдэд Говь-Алтай аймгийн Сутай хайрхан ууланд амжилттай авираа.

Уг авиралтын дараа сэтгүүлч П.Батболд ярихдаа: “Ууланд авирах хүмүүс яс үндэс, шашин шүтлэг, нас хүйс, үзэл бодол, өмч хөрөнгө үл харгалзан атгасан гар мэт нэг баг болон нягтрахгүй бол амжилтад хүрдэггүй шиг сэтгүүлч бид ард олны төлөө нийгмийн бусармаг бүхний эсрэг нэгдэн нягтарч ажиллах ёстой”.

Дэлгэрэнгүй: <http://www.monitoring.mn/index.php?module=record2&id=143&menuid=3>

Нээлттэй Нийгэм Форум, Лондон дахь Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн Хэвлэл Мэдээллийн Хөтөлбөрийн Сүлжээний санхүүжилтээр энэхүү сонин бичгийг эрхлэн гаргав.

Мониторингийн явц



"ГЛОБ ИНТЕРНЭШНЛ" ТББ



НЭЭЛТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

СЭТГҮҮЛЧИЙН ЭРХИЙН ЗӨРЧИЛ БА ҮЙЛДЭЛ

"Глоб Интернэшнл" ТББ 2005 оны 10-р сараас "Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн мониторинг ба хараат бус хэвлэл мэдээллийг дэмжих нь" төсөл хэрэгжүүлж эхэлснээс хойш бүсийн мониторингдоос 38 үйлдэлд дуудсан шуурхай мэдээ хүлээж авч, 12 мэдээг Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний олон улсын сүлжээ IFEX-аар, өөрийн вэб хуудсаар 15 мэдээг тус тус мэдээллээ.

IFEX-аар цацсан шуурхай мэдээний зөрчлийн хэлбэрийг дор үзүүлбэл:

Сэтгүүлчдэд халдсан 7 тохиолдол. Ийгл телевизийн сэтгүүлч Г.Батжав, Орхон аймгийн сэтгүүлч Б.Цэвэгмидийн эрүүл мэнд эрх чөлөөнд халдсан, "Ховдын мэдээ" сонины Ганчимэг, "Завхан" сонины эрхлэгч Идэр, "Үнэн" сонины сэтгүүлч Ш.Отгонжаргал нарыг мэдээллийн эх сурвалжаа илчлэхийг шаардсан багц мэдээ, "Өдрийн сонины" сэтгүүлч С.Энхтуул, "Хөвсгөлийн эрх чөлөө" сонины сэтгүүлч Ю.Гэрэлтуяа нарыг бичиж нийтлүүлсэнтэй нь холбогдуулан заналхийлсэн, Дархан-Уул аймгийн "7 хоног Дархан" сонины сурвалжлагч Т.Баясгалангийн эрх чөлөөнд халдсан, Ийгл телевизийн сэтгүүлч М.Батдорж, Т.Оргил, Б.Ууганбаяр, Л.Буянбат нарын ажлын багаж хэрэгсэл болох камерыг нь эвдсэн байна.

Мэдээлэл хайх, олж авах, түгээхэд саад хийсэн 3 тохиолдол. Өвөрхангай аймгийн сэтгүүлч Л.Мөнхдалай, Г.Пунцагсүрэн, Өмнөговь аймгийн сэтгүүлч н.Шинэхүү нарыг хурлаас хөөж мэдээлэл авах эрхийг нь зөрчсөн, Дархан-Уул аймгийн сэтгүүлч Т.Баярцогтод байгууллагад нэвтрэх зөвшөөрөл олгоогүй.

Сэтгүүлчдийг эрүүгийн гэмт хэрэгт буруутгасан 2 тохиолдол. "Өдрийн сонин"-ы улс төрийн тоймч Г.Дашрэнцэнг эрүүгийн хуулийн "доромжлох", "гүтгэх" зүйл ангиар буруутгасан, Сэтгүүлч Уянга, Г.Дашрэнцэн, судлаач Д.Ганхуяг нарыг нэр төр гутаасан хэргээр буруутгасан багц мэдээ.

Үйлдэл

Сэтгүүлчийн эрхийн зөрчлийн тухай "Глоб" IFEX-аар цацахын сацуу сэтгүүлчийн эрхийг зөрчиж байгаа талаар төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 8 мэдэгдэл хийж, холбогдох хууль зөрчин сэтгүүлчийн эрхэнд халдаж байгаа талаар хувь хүн, албан тушаалтнуудад 7 сонордуулах захидал илгээсэн. Тухайлбал: Сэтгүүлчийн мэдээлэл авах эрхийг зөрчсөн талаар Цагдаагийн Ерөнхий газрын дарга М.Сандаг-Очир; сэтгүүлчид байгууллагад нэвтрэх эрх олгоогүй Орхон аймгийн Цавчирт компанийн удирдлага; сэтгүүлчийн нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл авах эрхийг зөрчсөн ХЗДХ-ийн яамны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөлийн нарийн бичгийн дарга Ш.Даштүдэв; Өмнөговь аймгийн засаг дарга М.Ядмаа, аймгийн засаг даргын тамгын газрын дарга Н.Наранбаатар; иргэдийн мэдээлэл авах эрх зөрчигдөж байгаа талаар Ховд аймгийн засаг дарга Г.Нямдаваа; Орхон аймгийн цагдаагийн газрын дарга Д.Амарсанаа, Улсын мөрдөн байцаах газрын дарга М.Энх-Амгалан нарт сэтгүүлчийн эрх чөлөөнд халдсан хэргийг нэн даруй илрүүлэхийг шаардсан; мөн Дархан-Уул аймгийн "Тун" хоршооны ажилтан В.Сандагдоржид

холбогдох хууль зөрчин сэтгүүлчийн эрх чөлөөнд халдсан тухай сонордуулах захидлыг тус тус илгээсэн.

Сэтгүүлчийн эрхийн зөрчлийн талаарх шуурхай мэдээг IFEX-аар цацсаны дараа дэлхийн 500 мянга гаруй сэтгүүлчийг төлөөлдөг Олон Улсын Сэтгүүлчдийн Холбооноос /ОУСХ/ дараах уриалга бүхий 3 мэдэгдэл гаргажээ. Үүнд:

-Орхон аймгийн сэтгүүлчийн эрх чөлөөнд халдсан тухай шуурхай мэдээтэй холбогдуулан тус байгууллага эрх баригчдад хандан "Монголын сэтгүүлчдэд халдлагад өртөн айдас хүйдэсгүй ажил үүргээ гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд тэднийг дэмжиж, эрхийг нь хамгаалахыг" уриалсан байна.

-Өвөрхангай, Орхон аймгийн сэтгүүлчдийн мэдээлэл олж авах эрхийг зөрчсөнтэй холбогдуулан ОУСХ-ны Ерөнхийлөгч Кристофер Варрен "Эрх баригчид сэтгүүлчдэд мэдээлэл өгөхөөс татгалзаж, хууль ёсоор гэрчлэх баримтыг үгүйсгэж байгаа нь олон нийт бодит үнэнийг судлан мэдэх боломжийг хааж, улмаар өөрсдийгөө хаацайлах, гэм зэмгүй өнгөрөх орчин бий болгохыг чармайж байгаа хэрэг" гэж мэдэгджээ.

-Төвийн болон Ховд, Завхан аймгийн сэтгүүлчдийг бичсэн зүйлтэй нь холбогдуулан заналхийлж, эх сурвалжаа илчлэхийг шаардсан тухай шуурхай мэдээг IFEX-аар цацсаны дараа ОУСХ "Сэтгүүлчийг энэхүү дарамт шахалтаас ангижируулахын тулд сэтгүүлч мэдээллийн эх сурвалжаа нууцлах явдлыг хуульчлан баталж өгөхийг Монголын эрх баригчдад хандан уриалсан" мэдэгдэл хийсэн зэрэг болно.

ХАРИУ

Үйлдэлд дуудсан шуурхай мэдээг олон улсын сүлжээгээр цацах, хэвлэлийн мэдэгдэл, сонордуулах захидал үр нөлөөний тухайд:

- Өвөрхангай аймгийн Засаг дарга Б.Эрдэнэбилэг сэтгүүлчидтэй уулзахдаа Засаг даргын Зөвлөлийн хуралд орж, мэдээлэл авахад чөлөөтэй гэж мэдэгдсэн.

- Дархан-Уул аймгийн Цавчирт компанийн удирдлага сэтгүүлчийг үйлдвэрлэлийн талбарт нэвтрүүлээгүй менежерт анхааруулга өгч, сэтгүүлч Т.Баярцогтыг үйлдвэртээ ирж сурвалжлага хийхийг урьсан.

- Өмнө нь сэтгүүлчидтэй таагүй харилцдаг байсан Ховд аймгийн Иргэдийн төлөөлөгчийн хурлын дарга Н.Дамба хэлэхдээ сэтгүүлчидтэй харилцахдаа бид болгоомжтой байхгүй бол хэвлэл мэдээлэл их хүчтэй болж байна гэж мэдэгдсэн байна.

- Шүүмжлэлд өртсөн Завхан аймгийн Засаг дарга Л.Гансүх "Завхан" сонины эрхлэгч Б.Идэртэй түүний дараахан уулзахдаа: "Болохгүй бүтэхгүй зүйл байвал үнэнээр нь бичиж байх хэрэгтэй. Түүнээс хэн нэгнийг хардаж сэрдэн, санаанаасаа зохиож, гүтгээд байх юм бол уншигчгүй болно" гэж хэлээд явжээ. Хэвлэлийн мэдэгдлийн дараа өмнө нь сэтгүүлчидтэй таагүй харилцдаг байсан албан тушаалтнууд хандлагаа өөрчилсөн тухай бүсийн мониторинг мэдэлсэн юм.

"Глоб Интернэшнл" нь 1999 онд байгуулагдсан, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний олон улсын сүлжээ (IFEX)-ийн гишүүн, мэдээллийн болон хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага юм.

Бэлтгэсэн: Г.Нарангараа

Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэл нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. /Монгол Улсын Үндсэн хууль, 16 дугаар зүйл, 16 дахь хэсэг/



Соёлын гавъяат зүтгэлтэн
Хорлоогийн ЦЭВЛЭЭ

Түрүүч нь өмнөх дугаарт

ᠰᠠᠭᠠᠨ ᠵᠢᠨ ᠰᠤᠭᠠᠳᠠᠭ ᠪᠣᠳᠢᠲ ᠡᠷᠲᠦᠨᠴ ᠪᠠᠷᠠᠭ

Уран зохиол, сэтгүүл зүйн тусгадаг бодит ертөнц бараг танин мэдэгдээгүй атар онгоноороо л шинэ эздийгээ хүлээж байгаа. Сэдэв барагдашгүй. Ихэнх сэдэвт хүний гар ухаан хүрээгүй байна. Урлан бүтээх арга хэлбэр ч дуусашгүй. Шинэ шинэ сонин сайхан арга барил, урлахуйн ухаан, урлан бүтээх эв дүйг хүн төрөлхтөн олж эзэмшиж амжаагүй байна. Эрж олох л хэрэгтэй. Ирээдүйн сэтгүүлчдийн өнөөдрийн гараа эндээс эхэлж байж соёл иргэншлийн угтан золгох даяршлийн шинэ эриний хаалгаар нэвтэрч орох биз ээ.

Шуналт иргэншлийн хар хүчийг оюунлаг соёлт ертөнцийн гэгээн цагаан ухаарлаар сольж найрсаг энх амгалангийн эрин зууныг хөл дээр нь босгохын тулд сэтгүүл зүйг улам нигүүлсэнгүй, эгэл жирийн, өгөөмөр ул мөртэй болгох дэндүү их үйл хэрэг залуу эздээ хүлээж байна. Дуурайхуйн тухай товч зөвлөмжийг үүгээр цэглээ.

НИЙТЛЭЛИЙН ИЖ БҮРДЭЛ

Нийтлэлд иж бүрдлийн хууль байдаг. Сайхан бууз хийе гэвэл мах, гурил, сонгино, давс, шөл хэмээх бүрдлийг иж бүрнээр нь олж бэлдэх хэрэгтэй. Тэдгээрийн аль нэг нь байхгүй бол бууз нь бууз биш болно. Тэгвэл нийтлэлд яг ийм иж бүрдэл хэрэгтэй байдаг. Хэрэв аль нэг нь дутагдвал нийтлэл нь давсгүй эсвэл махгүй бууз шиг болдог гэсэн үг. Тэдгээр бүрдэлд юу ордог вэ? хэмээвээс ердөө тавхан зүйл ордог. Тэр нь товч, тодорхой, тогтоолттой, ойлгомжтой, сэтгэлд хүрсэн байх таван зүйл шаардлага ажээ.

Эдгээрийг бичлэгийн таван үндсэн хууль, нийтлэлийн таван амин сүнс, нийтлэлийн махбодь чанар гэхчлэн нэрлэх нь бий. Сонины бүтэн нүүр дүүрэн өгүүлэл, эсвэл хуруун чинээн өөдөсхөн мэдээний алинд ч гэсэн ялгаагүй тавуулаа иж бүрдлээрээ орсон байхыг шаарддаг.

А.ТОВЧ БАЙХ гэдэг нь санхүү аж ахуйн ойлголтоор зүйрлэвэл арвилан хэмнэх зарчим юм. Нийтлэлийн "ус"-ыг бүрэн шавхаж, илүүц үг, өгүүлбэр, сул яриаг бүрэн хасах замаар байж болох зохимжтой хэмжээнд хүртэл товчлохыг хэлнэ. Ус багатай нийтлэл ус агаар шиг хэрэгтэй тул дэлхийн бүх сонин үүнийг эрхэмлэдэг. Харин товч бичихийг "Бичгийн авьяас чадварын төрсөн эгч" гэж зүйрлэн үнэдэг билээ.

Нийтлэл заавал тав арван мөрөнд багтах ёстой гэсэн хэлбэрдсэн ойлголт байж таарахгүй. Үг, өгүүлбэр хоёрыг сайн "заазлаж" чадсан бол бүтэн нүүр дүүрэн, байсан ч том нь үл анзаарагдан уншигдах нь бий. Тэр нь том хэмжээгээр бичигдсэндээ биш товч бичигдсэндээ тэр. Товч бичигдсэн бүхэн хүнд бүрэн уншигддаг учиртай.

Энэхүү зарчмын чухал шаардлагыг сайн ухаж ойлгоогүйгээс зарим туршлага багатай залуу сэтгүүлчид үг ба мөрийн тоо хэмжээний "төмөр тор"-онд өөрийгөө хэт хашчихаад тухайлсан сэдвээ нухацтай сайн гаргаж чадахгүй хайран сайхан сэдвээ яйран болгож хаядаг байна. Тооны үзүүлэлтийн торонд баригдсан зарим сонинд аналитик сэтгүүл зүй, шинэ сэтгүүл зүй, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн шаардлага хангахуйц тулхтай сайн нийтлэл ховордож, бэсрэгхэн хэмжээнд баригдсан "авах гээх" юм багатай оронцог нийтлэл зонхилж байгаа нь туйлшрал мөн.

Б. ТОДОРХОЙ БАЙХ гэдэг нь санхүү аж ахуйнхны ойлголтоор зүйрлэвэл зарсан мөнгө бүхэн хүчин төгөлдөр баримтаар баталгаажсан байна гэсэн үг. Нийтлэл нь үг ба мөрийн тоогоор төдий биш харин нийтлэлд орсон шинэ баримт, шинэ санааны тоо хэмжээгээр үнэлэгдэнэ...

Зохиогч тухайн нийтлэлд хөндөж байгаа асуудлаа илүү

сайн судалж мэдсэн байдаг болохоор уншигч түмнийг төөрөлдүүлж байгаа талаас нь нэг мөр зөв ойлголт өгөхийг энэ зарчим шаарддаг нь мэдээж хэрэг ээ. Тодорхой байхын нэг шаардлага нь өөрийн нэр хаягийг болж өгвөл ил хэлбэл сайн. Нэрээ нуусан зохиогчийн материалд уншигчид хэр барагтайд итгэдэггүй.

В.ТОГТООЦТОЙ байх гэдэг нь сэтгэлд хоногшхуйц үлдэц сайтай байх утгаар нийтлэлийн практикт бууна. Тогтоогдож үлдэх гол арга нь нийтлэлээ бичихдээ давтамжтай хэллэгийг эгзэгтэй газарт нь зөв ашиглах явдал мөн. Ийм зорилготой тусгай хэлц хүртэл байдаг юм. "Өөрөөр хэлбэл", "Нэг үгээр хэлбэл", "Товчхон өгүүлбэл", "Бас дахин хэлэхэд", "Эцэст нь хэлэхэд" гэх мэт хэлхэц хэллэгүүд байдаг. Тэдгээр нь чихэнд ба нүдэнд түүнээс уламжлан сэтгэлд хоногшуулах өвөрмөц маягийн хэлц юм. Өөр арга олж эс чадвал ийм үгнүүд тус болно. Гэхдээ илүүдсэн бол нийтлэлийг усан нийтлэл болгоно.

Манай уран зохиолд давталтыг янз янзаар нь хэрэглэдэг тул тэндээс суралцах нь илүү үртэй байж таарна. Д.Нацагдоржийн "Эрүүл ба жаргал" хэмээх шүлэг бол давталтын сонгодог жишээ мөн.

*Жаргалан, жаргалан, жаргалан
Энэ ертөнцийн түмэн жаргалан
Түүний дотроос чухам жаргалан
Эрүүл энхийн нэгэн жаргалан*

Энэ бадгийг бараг хүн бүхэн чээжээр хэлж чаддаг. Магадгүй тэр нь яруу сонголонтой давталтын үр байж мэднэ. Жишээ алийг хэлж барнам. "Сур, сур, бас дахин сур". "Энэ бол миний төрсөн нутаг, Монголын сайхан орон". "Чулуун гар бол гар биш чулуу" гэх мэт ээ.

Г.ОЙЛГОМЖТОЙ гэдэг нь хялбаршуулах гэсэн утгаар сонины амьдралд бууна.

Нийтлэлийг хэлбэр зохиомж болон үг хэллэг, утга илэрхийллийн хувьд мэдлэг боловсрол нимгэнтэй наад захын уншигчийн түвшинд бүрэн ойлгогдох хэмжээнд хүртэл амар хялбар болгохыг хэлнэ. Дэлхийн нэр цуутай уран илтгэгчдийн үг хэл ийм л байдаг билээ. Хялбаршуулахын тулд юуны өмнө жалгын болон гадаадын үг, нэр томъёог бага хэрэглэх нь зөв бөгөөд гарцаагүй хэрэглэсэн бол тайлбар зүүлт дагалдуулах шаардлагатай. Хэнд уншуулах гэж зорьсноосоо шалтгаалаад шинжлэх ухааны нэр томъёог хэрэглэх хэмжээг баримжаалах нь зүйтэй болно.

Нийтлэл бүхэн өөрт тохирсон бичлэгийн хэлбэрээр бичигддэг. Нийтлэлийг энгийн ойлгомжтой болгодог тийм хэлбэр нь хүүрнэн өгүүлэхүй юм. Санаа бодлыг хамгийн энгийнээр, уншигч түмний унаган сэтгэлгээний хэллэгээр илэрхийлдэг тул уншигчаас их өргөн мэдлэг шаардахгүй ойлгогддог давуу талтай.

Д.СЭТГЭЛД ХҮРСЭН байх гэдэг нь нийтлэлээ бичихдээ чин сэтгэлээсээ бичих утгыг агуулна. Үүнийг уншигдахын хууль гэж болно. Нэгэнт өгч байгаа нийтлэлээ заавал уншуулахын тулд сонирхолтой арга зохиомж ашиглаж үйл явдал, мэдээ баримтыг "Амьдаар нь хүргэх" –ийг хэлж байна. Сэтгэлд хүрдэг сэдэв гэж байдаг, бас сэтгэлд хүртэл бичиж чаддаг уран чадвартай сэтгүүлч гэж байдаг.

Зарим хүн бичсэн зүйлээ албаны модон хэлтэй боллоо хэмээн голох нь үзэгддэг. Тэр нь үнэн сэтгэлээ өгч бичихгүй байгаагийн илрэл. Жинхэнээсээ уурлаж, уйлж, инээн

баясаж, үзэн ядаж, үр хүүхэд хань ижлээ өрөвдөж хайрлан энхрийлэхдээ өөрийн мэдэлгүй догдолж байдаг тэр агсныхаа төсөөллийг хадгалж бичвэл хэний ч бичсэн зүйл модон буюу албаны хэлтэй болохгүй. Жинхэнэ зүрх сэтгэлээсээ биш эрдэм ухааныхаа түвшингээс албадаж бичихээр албархуу маягтай болдог. Зохиогч сэтгэлээсээ бичсэн бол тэр нь уншигчийн сэтгэл зүрхэнд нь онож тусдаг гэж ойлгоход ташаарахгүй ээ.

Үг бүхэн үнэтэй

АД а а ЁЁ Ё Ё Ё Ё Ё Ё

Өвөөгийн нь жор үүгээр дууслаа. Одоо зөвхөн ерөөл хэлэх л үлджээ. Тиймээс “Үг мэтгэж гайхамшигийг туурвин бүтээх” -ийн учрал ерөөлийг дээш дээш нь өргөн дэвшүүлэе. Гайхамшиг гэж юуг хэлнэ вэ гэвэл миний төсөөлж байгаагаар дор дурдсан шиг уран чадварлаг бичихийг хэлж байна.

НЭГЭН ЖИШЭЭ

“...Дайралдсан хүн галзуу, согтуу нь үл мэдэгдэх хүүхний замаас зайлна. Лоовууз нь цасан дээр унахад Долгор мэдсэнгүй явсаар л байлаа. Нүд нь гөлрөн, үс нь салхинд сэвэлзэн хийсч явахад Долгор юу ч бодсонгүй. Түүний ухаан санаа юм бодох сөхөө ч үгүй байлаа.

...Урьд Тамирын эрэгт тулж очоод зогссонгүй. Мөсөн дээгүүр цас шажигнуулан явжээ. Өмнө нь байгаа уур савссан харз ч Долгорыг зогсоосонгүй. Нэг гишгэхдээ гүн усанд гишгээд далд орлоо. Гар нь хоёр дахин гялалзаад зузаан мөсний доогуур шурган алга боллоо.

Долгорыг цүлхийн ороход буцлан долгилсон Тамир хэдэн мөчийн дараа юу ч болоогүй юм шиг уур савсуулан мэлтэлзэж байлаа.

Хорвоо! Чи хүний зовлонд цадах болоогүй юу? ...”
(Ч.Лодойдамба. “Тунгалаг Тамир”)

НЭГЭН ЖИШЭЭ

“Намрын адаг сарын жавартай өглөө зузаан дээл шууж бүсэлсэн өвгөн Жанцан жижиг бор гэрийн эсгий үүдийг түнхэс хийтэл түлхэж хоол цайны илчинд залуу хүн шиг улаа бутран уур манан савсуулсаар түгдэгнэн гарч ирэхэд уяан дээр тохостой хэвтэж байсан хүрэн ат эзэн маань босгон дороо ойчих гэж явна уу гэсэн маягтай нүдээ дүрлийлгэн эргэж харав.

... Жанцан улцан нүднийхээ нулимсыг арчин, тэртээ зүүн хойно хэдмэгтэн хөхрөх уулсын бараагаар чиг барин товолзтол алхууллаа. Намрын сарын жаварт хамгийн түрүүн хамрын үзүүр хөрч, ус гоожно. Жанцан жавраас нүүр буруулан хазгайхан сууж жижиг аараг толгодыг хэдрэн алхуулсаар бага үдийн хэрд Босоогийн тал руу орж ирлээ.

... Сэтгэлийн зовлон гэгчийг хүн яахан тийм амар мартаж чадах билээ? Жанцан аавынхаа яриаг чагнан тэмээний алхааны аясаар нугастай юм шиг хойш урагш ганхан найгаж явахдаа Дагиймаагаа цаггүй ээнэгшин бодож зүрх нь шимширч явдаг байв.

-Надад чи ус шиг цэнхэр торго, маатан чихэр хоёр авчирч өгөөрэй дөө гэж доороос наалинхай харцаар ширтсээр гэнэн инээмсэглээд хоцорч байсан Дагиймаагийн хурц алаг нүдийг сэтгэлдээ үргэлж санаж, гол мөрөн, хөх тэнгэр юухан ч харсан ус шиг цэнхэр торго гэж захиад хоцорч байсан тэр бүсгүйн хонгор дуу чихэнд нь дуулдах шиг болж явдаг байжээ.

Гэвч нэг гэрийн тоонон доор толгой холбон ханийн жаргал эдлэх хувь тэр хоёрт байсангүй. Ус шиг өнгө гэж чухам энийг л хэлэх болов уу гэмээр цэнхэр торго авч биеэсээ ч салгалгүй баадагнан бүсэлж хоног тоолон жаргал мөрөөдсөөр Жанцан буцаад ирэхэд Дагиймааг өөр айлын бэр болгож хошуу гулсуулаад явуулчихсан байв”

(П.Лувсанцэрэн. “Ус шиг цэнхэр”)

НЭГЭН ЖИШЭЭ

Байдалд зохист намар цаг, сэтгэлд зохист яруу газар, Бэлэн далай гэдэг зөөлөн говь нутагт нэгэн хэсэг олон адуу сүрэглэн явахад адуу хэдийгээр алхлавч зөөлөн хуурай хөрс

нь адууны хөлд гишгэгдэж, улбар тоос бужигнан, улмаар зөөлөн салхинд туугдсаар цэлмэг агаарт замхарна.

....Эдэлсэн эзэн нь гэртээ дурлаж, эдлэгдсэн морь нь ижилдээ дурлаж, унасан морины толгойг хазаарын хүчээр эргүүлэвч бүхэл бие нь адууны зүг явж уурга ташуур хөшилдөөд, унасан морь тэмцэлдээд, тал дээгүүр ганц бие, адуун дотор ааш догширч, морины гуянд бүдүүн ташуур тас няс хийтэл адууны дундаас халиун морийг унасан, урт уурга чирсэн нэг гавшгай хүн гарч өмнө зүгийг чиглэн давхисаар нэг баялаг айлын гадаа буужээ. Энэ хүн гучаад настай, махлаг хөх царайтай, толгойд хир болсон хөх цууямбуу зангиджээ. Нэр Долингор гэдэг. (Ц.Дамдинсүрэн “Гологдсон хүүхэн”)

НЭГЭН ЖИШЭЭ

“... Хөглөгөр их хэц хөндөлсөн цэнхэртэнэ.

“Чамай мууг даа! Ижийгий минь яаж зодож тарчлаадаг байлаа. Юу, юу гэж эцгий минь ясыг өндөлзүүлдэг байлаа. Гайгүй ээ! Хүний үр, нохойн зулбадас хоёрын аль нь болохоо өнөөдөр чамд үзүүлнэ дээ, чүү!”

Гүвээ толгод хойгуур урдуур шоволзон босч ирэвч төдөлгүй ард хоцорно.

“Мэдээж, чи муу намайг танихгүй. Эцэг эхийн минь нэрийг дуулаатахтай зэрэг царай зүс чинь ямар болохыг харнаа, гайгүй”.

Гэнэт тал мэлсхийн цэлийж, хоёр гурваар хотлон зусах айлуудын бараа бөнбөлзөв” (Д.Батбаяр “Гашуун”)

Энэчлэн гэрэлт сайхныг чихэнд сонсдож, нүдэнд харагдтал нь, гай зовлонгийн гашуун нэхүүнийг аманд амтагдаж, хамарт үнэрттэл нь бичиж чадахыг үгээр урлан бүтээхийн гайхамшиг гэж болох учиртай.

Үгээр урлан бүтээхийн гайхамшиг гэж байхын хамт бас үгээр үйлддэг гамшиг гэж бий. Дэлхийд сургамжтай болсон ганц баримт дурдъя. Дэлхийн чөлөөт хэвлэлийн хаан гэж алдаршсан У.Хёрст гэгч улс нийгэмд сөргөлдсөн зөрчил бий болгох, яс хаях талаараа гарамгай хүн байсныг сонссон байх. Тэр бээр нэгэн удаа АНУ ба Испани хоёр улсын засгийн газар хоорондын зөрчлийг ашиглан удаа дараа шуугиан дэгдээж байгаад эцэст нь АНУ-ын засгийн газрыг Испанийн эсрэг дайн зарлахад хүргэж байсан сургамжтай түүх байдаг. Ер нь 1898 онд болсон АНУ-Испанийн дайныг сенсат сэтгүүл зүйн практикт гарч ирсэн оргил нь гэж үздэг. Хамгийн хачирхалтай нь У.Хёрстын сонинд нийтэлсэн нэг муу хуурамч захиа АНУ-гийн ард түмнийг зэвүүцүүлснээс засгийн газартаа Испанитай дайтах шаардлага тавихад хүргэсэн гэдэг юм билээ. Гэтэл Испанийг оргүй гүтгэсэн тэр захиаг тэдний хэн нэг сэтгүүлч бичээгүй, харин У.Хёрст өөрөө зохиож хөлсний хүн ашигласан байдаг. Энэ дайнаас У.Хёрстын хэвлэл их ашиг (500 сая долларын) олж, бараг л язартлаа баяжсан тухай сэтгүүл зүйн түүхэнд бичигдсэн бий. Хурц цочмог зантай монголчууд байтугай хүлээц тэвчээртэй америкчууд хүртэл нэг өчүүхэн зохиомол захиад хууртагдаад цэрэг эрсийнхээ халуун цусыг ургасан энэ түүхийг сануулах нь илүүц биш байж магадгүй.

Монгол хэл бол монгол ухааны оньсон түлхүүр. Үүнээс үүдээд залуу сэтгүүлчид “Аялгуу сайхан монгол хэлээ ядуурал, гадаад хэлний түрэмгийллээс аврах” монгол хэлээрээ гай гамшиг дуудахгүй байх талаар тэргүүн эгнээнд хошуучлахыг өрөөе.

Х.Цэвэлээ (МУСГЗ)



Хуульч зөвлөж байна

Сэтгүүлч ба эрх зүй

Сэтгүүлчдийн мэргэжлийн үүргийн нэгээхэн хэсэг нь ард түмний дуу хоолой, сонсох чих нь болж, эрх мэдэлтүүдийн хууль бус алхам бүрийг олон нийтийн хэлэлцүүлгийн тавцанд гаргаж тавьж байх явдал байдаг. Энэ үүргээ гүйцэтгэх явцдаа ямар нэгэн байдлаар хууль эрх зүйн харилцаатай холбоотой бэрхшээлтэй тулгардаг. Жишээ нь, манай байгууллагын хэрэгжүүлж байгаа “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн мониторинг ба хараат бус хэвлэл мэдээллийг дэмжих нь” төслийн хүрээнд сэтгүүлчдэд хуулийн зөвлөгөө үнэ төлбөргүй өгч байгаа юм. Манайд хандан хууль эрх зүйн зөвлөгөө авахаар хүссэн арван гурван сэтгүүлч байгаагаас шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой нэг, сонинд нийтэлсэн мэдээллийнхээ үнэн бодитойг шүүхийн өмнө нотлох шаардлага тулгарсан дөрөв, мэдээллийнхээ нууц эх сурвалжийг хэлэхийг шаардсан гурав, хууль бусаар түр саатуулагдсан нэг, заналхийлэлд өртсөн нэг, зодуулсан нэг, хуулийн зүйл заалтын агуулгыг тайлбарлуулах нэг, сонины нэг удаагийн дугаарыг бүгдийг худалдаанд гарахаас нь өмнө хураан авсан нэг гэсэн асуулт хуулийн зөвлөгөө өгсөн байна. Эдгээрээс гадна интернэтээр онлайн зөвлөгөө мөн өгсөн билээ. Онлайн зөвлөгөөг нийт дөрвөн удаа өгсөн байгаа бөгөөд үүнд эх сурвалжтай холбоотой нэг, Олон нийтийн радио телевизийн үндэсний зөвлөл ямар тохиолдолд огцрох, яамдын хэвлэлийн төлөөлөгч гэж ямар албан тушаалтанг хэлдэг, нийгэм хангамжтай холбоотой нэг нэг асуултууд байсан болно.

Эдгээрээс харахад хамгийн олон удаа тохиолдсон асуудал нь бичиж нийтэлсэн зүйлээсээ болж бусдын нэр төрд халдсан хэмээн шүүхэд дуудагдсан бөгөөд мэдээлэл бодит үнэнд нийцэх эсэхийг өөрөө нотлох үүрэг хүлээсэн дөрөв байна. Иргэний хуулийн 21 дүгээр зүйлд “Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ” гэж заасан байдаг. Мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйлд “Зохигч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд өөрийн шаардлага ба татгалзлын үндэс болж байгаа байдлын талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй” гэж заасан зэргээс харахад сэтгүүлчид дараа нь хуулийн төвөгтэй асуудалтай тулгарахгүй байхын тулд эргээд өөрийгөө хамгаалах олон талын эх сурвалж болон нотлох баримтаар мэдээллээ сайн баримтжуулах хэрэгтэй юм. Энэ нь мөн манай улс хэвлэлийн эрх чөлөөгөө сайн хамгаалдаггүйн бодит жишээ юм. Өөрөөр хэлбэл, АНУ хэвлэлийн эрх чөлөөг хамгаалахын тулд 1964 онд дээд шүүх нь олны танил, олон нийтийн анхаарлын төвд байнга байдаг хүмүүс өөрийнх нь нэр төр, алдар хүндтэй холбоотой мэдээлэлд гомдол гаргах бол эхлээд өөрийнх нь эсрэг санаатайгаар нэр төрийг унагах зорилго агуулж нийтэлсэн байна гэдгийг нь нотолж чадахгүй бол нэхэмжлэл гаргах эрхгүй, тийм нэхэмжлэлийг шүүх нь авч хэлэлцэхгүй байхаар шийдвэр гаргасан байх юм. Манай улс ч гэсэн Үндсэн хуульдаа тодорхойлсон “Хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх эрхэм зорилго”-доо хүрэхийн тулд дээрх хуулийн зохицуулалтыг бий болгох нь гарцаагүй юм.

Нууц эх сурвалжтай холбоотой түүнийг илчлэхийг шаардсан тохиолдол мөн дөрөв байна. Энэ нь одоогоор хангалттай хуулиар зохицуулж чадаагүй байгаагаар холбоотой юм. Нууц эх сурвалжаа нууцлах үүргийг Олон

нийтийн радио, телевизийн тухай хуулийн 34.2 дугаар зүйлд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж шүүх үзэж ил болгосноос бусад тохиолдолд олон нийтийн радио, телевизийн ажилтан мэдээллийн эрх сурвалжийг нууцлах эрхтэй” гэж заасан. Гэхдээ энэ заалт Олон нийтийн радио, телевизийн сэтгүүлчдээс бусад хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчдэд хамаарахгүй. Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлээс баталсан Монголын сэтгүүлчдийн ёс зүйн зарчмын 4 дүгээр зүйлд “Хүний итгэлийг олсон мэдээллийнхээ эх сурвалжийг ямар ч тохиолдолд чанад нууцална” гэсэн байх, мөн Олон Улсын Сэтгүүлчдийн Холбооноос баталсан Сэтгүүлчдийн баримтлах зарчимд “Итгэл хүлээж олж авсан мэдээллийн уг сурвалжтай холбогдох мэргэжлийн нууцыг сэтгүүлч хадгалж байх” гэж заасан байна. Хэдийгээр хуульчилсан байдал хангалтгүй байгаа боловч дээр дурдсан Ёс зүйн зарчмуудад орсон заалтуудыг баримтлан ажиллах бололцоотой юм. Ер нь бүх сэтгүүлчдийг нууц эх сурвалжаа нууцлахтай холбоотой харилцааг хуульчлахгүй бол ялгаварлан гадуурхсан байдал үүсэж болзошгүй юм. Өөрөөр хэлбэл, Олон нийтийн радио, телевизийн сэтгүүлч нууц эх сурвалжаа нууцалж болдог бусад болохгүй мэт нөхцөл байдал үүсэж болох юм.

Эдгээрээс гадна сэтгүүлчдийн өөрсдийнх нь хуулийн мэдлэг, цаашилбал хүний эрхийн талаархи мэдлэгийг дээшлүүлэх нь маш чухал. Хуулиа мэдэж байгаа сэтгүүлчийн бичсэн нийтлэл нь бусдаасаа ямагт илүү чанартай байх магадлалтай юм. Энэ нь зөвхөн нийтлэл бичихээс гадна бусадтай харилцахад ч гэсэн хэрэгтэй билээ. Хуулийн зүйл заалтын агуулгыг тайлбарлуулахыг хүссэн нэг тохиолдол нь Олон нийтийн радио, телевизийн сэтгүүлчид өөрсдөө ёс зүйн дүрмээ батлах боломжтой эсэх, Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 24.1.1 дүгээр зүйлд “Олон нийтийн радио, телевизийн дүрэм болон тэнд ажиллагсдын ёс зүйн дүрэм батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах” (Үндэсний зөвлөлийн бүрэн эрх) гэсэн заалтыг хэрхэн ойлгох вэ гэсэн асуулт юм. Үндэсний зөвлөл нь байгууллагынхаа дүрэм, ажилчдийнхаа ёс зүйн дүрмийн аль алийг нь эцэслэн батлах эрхтэй бөгөөд өөр хэн нэгэн этгээд буюу тухайн байгууллагын ажилчид өөрсдөө ямар нэг дүрэм батлах эрхгүй байхаар хуульчилсан нь тохиромжгүй зохицуулалт гэж үзэж байна. ОНРТ-ийн сэтгүүлчид өөрсдөө ёс зүйн дүрмээ баталж дагах мөрдөхөд хөндлөнгийн оролцоо, хэн нэгний үүрэгдэлт байх шаардлагагүй юм. Энд ёс зүйн дүрэмтэй холбоотой жишээ дурдахад Өмгөөлөгчийн ёс зүйн дүрмийг Монголын Өмгөөлөгчдийн Холбоо баталдаггүй, харин Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Бүх гишүүдийн саналаар сонгогдсон Их Хурал баталдаг юм.

Сэтгүүлчдэд хууль зүйн зөвлөгөө өгч байхад ажиглагдсан нэг зүйл нь сэтгүүлчид олон талын эх сурвалжаар мэдээллээ баталгаажуулж байгаагүйгээс шүүх дээр очихоороо мэдээллийнхээ үнэн бодитойг нотолж чадахгүйд хүрч, өөрийгөө хамгаалах асуудал нь орхигддог болох нь харагдсан. Үүнийг Олон Улсын Сэтгүүлчдийн Холбооны ёс зүйн зарчмын 3 дугаар зүйлд **“Сэтгүүлч цаад эх сурвалжаар нь мэдэх зөвхөн тийм л баримтуудад тулгуурлан бичиж мэдээлж байх...”** гэж заасан байдаг.

Иймээс сэтгүүлчдийн нийтэлж нэвтрүүлсэн зүйлээсээ болоод бусдын нэр төрд нь халдсан гэж буруутахгүй, цаашилбал, мэргэжлийн нэр төрөө ард түмний дунд өндөрт өргөж, олон нийтийн анхаарал татсан асуудалд хоточ нохойн байдлаар хандаж, тэдний шүүмжлэлд өртсөн нийгмийн буруу үзэгдлийг холбогдох хүмүүс засаж залруулахын төлөө хичээн ажиллах сэтгэлгээтэй болно гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Бэлтгэсэн: Хуульч Давдзхуу

Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар, эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана. /Иргэний болон Улс төрийн эрхийн тухай Олон Улсын Пакт, 19 дүгээр зүйл/

Тэд асууж байна

СЭТГҮҮЛЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД СААД ТОТГОР УЧИРВАЛ...

----- Ховд аймаг -----

Асуулт 1: Нээлттэй шүүх хурлаас мэдээлэл авахад заавал Ерөнхий шүүгчээс зөвшөөрөл авах ёстой юу?

Хариулт: 1998 онд Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс гаргасан тогтоолд нээлттэй шүүх хуралдааныг сурвалжлахад тухайн шүүхийн Ерөнхий шүүгчээс заавал бичгээр зөвшөөрөл авах ёстой гэж заасан байсан. Харин 2006 оны 10 сарын 13-нд Шүүхийн Ерөнхий Зөвлөл энэ тогтоолоо шинэчлэн баталсан бөгөөд энэ тогтоолын хавсралтаар баталсан журамд сэтгүүлч шүүх хуралдааны эхлэл төгсгөлд гэрэл зураг авах болон ямар нэг техник хэрэгсэл ашиглах тохиолдолд шүүх бүрэлдэхүүнээс зөвшөөрөл авна гэж заасан байна. Харин техник, хэрэгсэл ашиглахгүй тохиолдолд хэн нэгнээс ямар нэг зөвшөөрөл авах шаардлагагүй юм.

Асуулт 2: Хөдөөгийн сэтгүүлч бид ажил үүргээ гүйцэтгэсний төлөө дарамтлуулах, доромжлуулах гэх мэтээр сэтгэл санааны хохирол амсдаг. Үүнд эрхээ хэрхэн хамгаалуулж, хариуцлага тооцох вэ?

Хариулт: Сэтгүүлч хүн ажил үүргээ гүйцэтгэсэн гэдгийг эндээс ямар нэг мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэлж, нэвтрүүлсэн гэж ойлгож байна. Энэ нийтэлсэн нэвтрүүлсэн зүйл нь нийгмийн буруу үзэгдлийн тухай шүүмжилсэн нь түүнд нэр дурдагдсан этгээд гомдож (дургүйцэж, уурлаж) “Энэ мэдээ миний нэр төрд халдсан байна, огт үнэн бодит байдалд нийцэхгүй, намайг гүтгэсэн байна, доромжилсон байна” гэдэг. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт **Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх...** гэж заан Монгол Улсын иргэний эрхийг баталгаажуулсан байдаг учраас тэдгээр хүмүүс нэр төрөө хуулиар хамгаалуулахаар холбогдох байгууллагад хандах эрхтэй. Гэтэл энэ эрхээ эдлэхгүйгээр мэдээлэл гаргасан сэтгүүлчийг ямар нэг байдлаар дарамталж, доромжилж байгаа бол энэ нь өөрөө хууль бус үйлдэл юм. Сэтгүүлчийн мэргэжлийн үүрэг нь ардчилсан нийгэмд маш өндөр ач холбогдолтой байдгийг хүлээн зөвшөөрч сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийг Эрүүгийн хуулиар хамгаалсан байдаг. Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлд “өөрийн болон бусдын ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг тараах болон тараалгахгүй байхын тулд сэтгүүлчийн хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийсэн бол... гэж томъёолон гэмт хэрэгт тооцож ял шийтгэхээр заасан байдаг. Энэхүү зөрчигдсөн эрхээ сэргээлгэх шаардлагатай гэж та үзвэл Цагдаагийн байгууллагад хандан гомдол гаргах эрхтэй.

Асуулт 3: Төрийн албан тушаалтнууд орон нутгийн сэтгүүлчид, төвийн хэвлэл мэдээллийн сэтгүүлчдийг ялгаварлан харьцдаг. Тэд орон нутгийн сэтгүүлчдэд та нар бидний араас гүйж мэдээлэл авах ёстой гэсэн байдлаар ханддаг. Энэ нь эрхийн зөрчилд хамаарах уу? Дарга нар өөрийгөө магтуулах дуртай, шүүмжлэл бичвэл мэдээлэл өгөхгүй байх, ялгаварлан гадуурхах тохиолдол байнга гардаг.

Хариулт: Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “**Хүнийг** үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, **эрхэлсэн ажил, албан тушаал**, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь **ялгаварлан гадуурхаж үл болно...**” гэж заасан байдаг. Тэгэхээр энэ заалтын эсрэг үйлдэл болон эс үйлдэхүй нь эрхийн зөрчил мөн юм. Энэ тохиолдолд

дээд шатны албан тушаалтанд нь хандан гомдол гаргаж болох бөгөөд дээд шатны албан тушаалтны гаргасан шийдвэрийг та эс зөвшөөрвөл шүүхэд хандан гомдол гаргаж болно.

Асуулт 4: Би нөхөрсөг шог зураг зурдаг. Миний зурсан зурагтай холбогдуулан хүмүүс гомдол гаргавал яах вэ?

Хариулт: Таны Үндсэн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөөг хэн нэг нь зөрчсөн тохиолдолд та хуулийн дагуу хэд хэдэн байгууллагад хандан гомдлоо гаргаж болно. Таны эрх чөлөөг зөрчсөн үйлдлийн шинж чанар, хэлбэрээс хамаараад буюу эрүүгийн гэмт хэргийн шинжтэй бол Цагдаагийн байгууллагад хандах, иргэд хоорондын эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцаанд үүссэн эрхийн зөрчил бол шүүхэд хандах, төрийн захиргааны байгууллага бол гаргасан шийдвэр нь олон нийтэд чиглэсэн шинжтэй байгууллагуудаас гаргасан шийдвэр нь таны эрх чөлөөг зөрчсөн байвал захиргааны хэргийн шүүхэд хандах ба энэ тохиолдолд захиргааны хэргийн шүүхэд хандахаас өмнө тухайн албан тушаалтны дээд шатны байгууллага, албан тушаалтанд хандсан байх шаардлагатай. Эдгээрээс гадна монгол улсын хүний эрхийн үндэсний комисст гомдлоо гаргаж болно. Хүний эрхийн үндэсний комисс таны гомдлыг хянаад гаргах шийдвэр нь заавал биелэгдэх шинжгүй, зөвлөмжийн хэлбэртэй гардаг. Мөн олон улсын хүний эрхийн байгууллагуудад хандаж болно.



----- Орхон аймаг -----

Асуулт 5: Залуу сэтгүүлчдийг үл тоомсорлож мэдээлэл өгөхгүй байх нь түгээмэл. Сэтгүүлчийн мэдээлэл олж авахад хойрго хандаж цааргалсан хүнд ямар шийтгэл оноох вэ?

Хариулт: Зарим хуульд төрийн албан хаагчдыг мэдээлэл заавал өгөх үүрэгтэйгээр хуульчилсан байдаг. Тэгэхээр бүх хуульд заасан шийтгэл нь хоорондоо харилцан адилгүй. Жишээ нь: Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 9.3 дугаар зүйл, 9.4 дүгээр зүйлүүдэд “Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон ийм үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага сонгуулийн үйл ажиллагааны талаар үнэн зөв, бодитой мэдээлэл түгээх үүрэгтэй /9.3/ гэж заасан болно.

Энэ хуулийн 9.2-т заасныг зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн, ажилтныг 150000-250000 төгрөгөөр, 9.3-т заасныг зөрчсөн хэвлэл, мэдээллийн байгууллагыг 600000-800000 төгрөгөөр, албан тушаалтныг 200000-250000 төгрөгөөр торгоно /9.4/” гэж заасан.

Ер нь төрийн албан хаагчид төр, байгууллага хувь хүний нууцад хамаарахаас бусад тухайн байгууллагад хадгалагдаж байгаа мэдээллийг сонирхсон хүнд заавал өгөх ёстой байдаг.

Редакцийн булан: Сонин бичгийн талаар сэтгүүлчдийн дунд явуулсан судалгаагаар сэтгүүл зүйн сүүлийн үеийн чиг хандлагын талаар уншиж сонирхох хүсэлтэй байгаагаа сэтгүүлчид илэрхийлсэн билээ. Энэ удаа бид иргэний сэтгүүл зүйн талаарх дараах материалыг бэлтгэн толилуулж байна.

Иргэний сэтгүүл зүй

Шайн Боумэн болон Крис Уиллисийн “Уншигч, сонсогчид мэдээ болон мэдээллийн ирээдүйг хэрхэн тодорхойлодог вэ?” илтгэлд дурдсанаар “Иргэний сэтгүүл зүй” буюу оролцооны сэтгүүл зүй гэдэг нь мэдээ мэдээллийг цуглуулах, нийтлэх, дүн шинжилгээ хийх, тараахад иргэдийн идэвхтэй оролцоог хэлдэг байна. “Хараат бус, найдвартай, тодорхой, өргөн хүрээг хамарсан мөн ардчилалд шаардлагатай мэдээллийг хангахад энэхүү оролцооны гол зорилго оршиж байгаа юм. “Иргэний сэтгүүл зүй” (citizen journalism) мэргэжлийн сэтгүүлчид оролцдог хотын сэтгүүлзүйтэй (civic journalism) хольж хутгаж болохгүй.

Ж.Д.Ласика 2003 онд “Интернэт сэтгүүл зүйн тойм” нийтлэлдээ хэвлэл мэдээллийн хэрэгслийг иргэний сэтгүүл зүйн дараах төрөлд ангилжээ: 1. Үзэгч, уншигч, сонсогчийн оролцоо (мэдээ нийтлэлд хэрэглэгчийн тайлбарыг хавсаргах. Тухайлбал: хувийн блог, гар утсаар авсан гэрэл зураг эсвэл видео бичлэг, орон нутгийн оршин суугчийн бичсэн орон нутгийн мэдээ) 2. Бие даасан мэдээ, мэдээллийн вэб хуудсууд (Consumer Reports, Drudge Report) 3. Бүрэн шаардлага хангасан оролцооны вэб хуудас (Ohmynews) 4. Хамтын ажиллагааны болон хувь нэмэр оруулах хэвлэл мэдээллийн сайтууд (Slashdot, Kuro5hin) 5. “Нарийн хэвлэл мэдээллийн” бусад төрөл (мэйлийн жагсаалтаар мэдээлэл түгээх, сонин бичиг) 6. Хувийн өргөн нэвтрүүлгийн сайтууд (видео өргөн нэвтрүүлгийн сайтууд тухайлбал (KenRadio)

Улс төр, иргэний асуудлаарх олон нийтийн үнэлэмж буурах хандлага газар авсан, мөн мэдээллийн хэрэгсэлд итгэх итгэл буурч байсан тэр үед буюу 1988 онд болсон АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа олон нийтийн сэтгүүл зүйн хөдөлгөөн үүсэж хөгжсөн байна.

Тэр үед мэргэжлийн сурвалжлагч нарын ажлын арга барилыг өөрчлөх замаар “хүмүүсийн төлөө” сэтгүүл зүйг дэмжихэд чиглэсэн олон нийтийн сэтгүүл зүйн талаар анх ярьж эхэлжээ. Харин одоо интернэт болон вэблог (webblog), харилцан ярианы хэсэг (chat room) мэдээллийн самбар, компьютер бүхий үүрэн телефон утас зэрэг сүлжээний технологи үүсэж бий болсны хэрээр “хүмүүсийн бүтээсэн” сэтгүүл зүй цэцэглэн хөгжиж байна.

ThemeParkInsider.com 2001 онд сэтгүүл зүйн томоохон шагнал хүртсэн анхны он-лайн нийтлэл юм. Колумбийн сэтгүүл зүйн сургууль болон Мэдээллийн он-лайн холбооноос Сэтгүүл зүйн он-лайн шагнал хүртсэн уг вэб хуудасны “Ослын ажиглалт” буланд хүмүүс соёл амралтын хүрээлэнд элдэв зугаацуулах тоглоомоос бэртэл авч байгаа ослыг тогтоож, үүнээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө тавьсан байжээ. 2004 оны АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр Ардчилсан болон Бүгд найрамдах намынхан нэр дэвшигчийг тодруулах хуралдааныг сурвалжлах эрхийн үнэмлэхийг иргэн сэтгүүлчдэд /blogger/ олгосон нь мэргэжлийн бус сэтгүүлчдэд итгэх итгэл нэмэгдэж, тэдний нөлөө шинэ төвшинд гарсныг харуулсан юм. Зарим иргэн сэтгүүлчид мэргэжлийн сэтгүүлчдийн ажлыг ажиглан, тэдний бүтээл бодитой, тодорхой байгаа эсэхэд мониторинг хийх болжээ.

“Бид уламжлалт сэтгүүл зүйг дээрээс нь доошоо өөрчилсөн. Хүмүүст юу чухал болохыг хэлэх нь мэдээ биш юм. Тиймээс бид хаалгачийн хувьд үүдээ нээгээд хүмүүсийг оруулах болсон. Бид бүх мэдээллээ редактор болон сэтгүүлч зэрэг цөөн бүлгийн шүүлтүүрээр дамжуулан уншигчдад хүргэх бус дуу хоолойгоо сонсгох нүд, чих болсон мянган мянган уншигчтай нийгмийн сонин байхыг илүүд үзэж байна” хэмээн АНУ-ын Калифорни муж улсын Бэйкерсфилдийн “Northwest Voice” хэвлэн нийтлэгч Мэри Лю Фолтон ярьсан байна.

Шүүмжлэл

Иргэн сэтгүүлч нь тухайн бичиж, нийтэлж буй хэсэг бүлгийнхээ идэвхтэн байж болдог. Өдөр тутмын гол хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэг болох “Нью-Йорк Таймс” гэх мэт мэдээллийн байгууллагууд “бодитой байх” гэсэн уламжлалт зорилгоо орхигдуулдаг хэмээн олон нийтийн сэтгүүл зүйг баримтлагчдыг шүүмжилдэг байна.

Том Грубиш иргэний сэтгүүл зүйн 10 шинэ сайтыг судлахад тэдний олонх нь мэдээний чанар болоод агуулгын хувьд хангалтгүй байгаа талаар 2005 онд бичсэн нийтлэлдээ дурджээ.

Иргэний сэтгүүлзүй гэсэн ойлголтод иргэний харъяалалгүй олон сая хүн хамаарах эсэх нь тодорхойгүй учир хэвлэл мэдээллийн зарим байгууллагууд энэ ойлголтыг “ардын”, “оролцооны” сэтгүүлзүй г.м-ээр нэрлэхийг санал болгож байгаа юм.

Эх сурвалж: Wikipedia үнэгүй нэвтэрхий толь
http://en.wikipedia.org/wiki/Citizen_journalism

Иргэн-сурвалжлагчид Өмнөд Солонгосын сайтад бичиж байна.

СӨҮЛ, Өмнөд Солонгос (АП)- Байгууллагад гурван жил болж байгаа Өмнөд Солонгосын “Ohmynews” (үгчилбэл “Хөөх миний мэдээ”) интернэт сайтад тус улсын Ерөнхийлөгч Ну Му Хён 2005 оны хоёрдугаар сард Ерөнхийлөгчийн тангараг өргөснийхөө дараа анх удаа ярилцлага өгснөөр тус сайтын нэр хүндийг өргөжээ. Энэ сайтад орон нутгийн хов жив, улс төр гээд бүхий л сэдвээр “иргэн-сурвалжлагч” нар мэдээ нийтлэл бэлтгэж тавьдаг байна.

Интернэт нь Өмнөд Солонгост сэтгүүл зүйн шинэ төрөл үүсэхэд нөлөөлж байна. Тухайлбал, эмч, оюутан, профессор болон гэрийн эзэгтэй гэхчлэн жирийн иргэд сурвалжлагчаар ажилладаг “Омайньос” сайт нь ихээхэн нэрд гарсаар байна. “Хүн ард зөвхөн өдөр тутмын гол хэвлэл мэдээллийн хэрэгслийн нүдээр дамжуулан аливааг харж байсан 20-р зууны сэтгүүлзүйг бид баяртай гэж хэлмээр байна” хэмээн энэ сайтыг үндэслэгч, хянан тохиолдуулагч О-Юун-хо мэдэгдэв.

О-Юунхо-гийн хэлснээр өдөрт дунджаар 1.2 сая хүн зочилдог “Омайньос” сайтын энэ арга нь нийтлэлийн бодит байдал болон чанарт эргэлзэх хүмүүсийн тоог нэмэгдүүлсээр байгаа юм. “Маркетингийн ажилтан, идэвхтнүүд өөрсдийн бүтээгдэхүүн болон үзэл санааг сурталчлахын тулд сэтгүүлчээр ажиллахыг үгүйсгэхгүй” хэмээн Өмнөд Солонгосын томоохон хэвлэлийн нэг “Чосон Илбо” сонин ахлах редактор Чой Жун-сук ярих. “Интернэт сэтгүүлийн чанар томоохон асуудлыг нэг болоод” байна хэмээсэн түүнтэй “Омайньос” сайтын хянан тохиолдуулагч О-Юун-хо санал нийлэхгүй байна. “Бүх мэдээг интернэтэд тавихаас өмнө мэргэжлийн сэтгүүлчид хянан тохиолдуулж, баримтыг шалгадаг. Зөвхөн 2 мэдээнд л нэр төр гүтгэлгийн холбогдолтой хэрэг үүсгэсэн” гэжээ.

Одоогийн байдлаар 26300 уншигч иргэн-сурвалжлагчаар ажиллахаар бүртгүүлсэн бөгөөд тэд өдөрт 200 мэдээ бичдэг байна. Электрон сонины нийт мэдээ материалын 80 орчим хувийг олон нийт, үлдсэн хувийг “Омайньос”-ийн мэргэжлийн 38 сэтгүүлч, редактор бэлтгэдэг аж.

Мэдээний ач холбогдлоос хамааран иргэн-сурвалжлагчид огт мөнгө төлдөггүй буюу 16 хүртэлх доллар төлдөг.

Өмнөд Солонгос интернэт хэрэглэгчдийнхээ тоогоор дэлхийд дээгүүрт орж байгаа нь “Омайньос” сайт болон бусад мэдээллийн сайтын нэр хүнд хурдацтай өсөхөд нөлөөлж байгаа аж. Тус улсын нийт өрхийн 70 орчим хувь нь интернэтэд холбогдсон нь дэлхийн аль ч орныхоос өндөр үзүүлэлт юм. www.ohmynews.com

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй. /Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, 3 дугаар зүйл, 1 дэх хэсэг/

Далайд дусал

Олон нийтийн эсэргүүцлийн үйл ажиллагааг хэрхэн зөв зохион байгуулах вэ?

Хүчирхийллийн бус идэвхтэй үйл ажиллагаа гэж юу вэ?

Онцгой нөхцөл дэх сэтгүүлчдийн төв 2000 оноос сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын эрхийн зөрчлөөс гадна олон нийтийн эсэргүүцлийн арга хэмжээнд мониторинг хийж байгаа билээ. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, тодорхой нэг сэтгүүлчид аливаа дарамт үзүүлсэн үед эгдүүцэж, сэтгэл түгшиж байгаагаа олон нийтэд мэдээлэх нь өөрийн эрх болоод үүрэг хэмээн үздэг тухайн нийгэм, сэтгүүлчийн үйл ажиллагааг тодорхойлоход уг мониторингийн гол зорилго оршиж байна. Өөрийн эрхээ хамгаалах болон үзэг нэгт нөхдөд нь учирсан дарамтыг эсэргүүцэн сэтгүүлчид гурван жилийн дотор хоёр зуу гаруй эсэргүүцлийн арга хэмжээ зохион байгуулсныг тус төв бүртгэн авчээ. Дараах жишээг танилцуулбал:

“Репортер” сонины ерөнхий эрхлэгч Анжел Писальникийн эсэргүүцлийн арга хэмжээ Гродно, 2000.06.03

“Репортер” сонины ерөнхий эрхлэгч, сэтгүүлч Анжел Писальник болон түүний хамтран ажиллагсдынх нь мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хэдэн сарын турш хориглосон орон нутгийн эрх баригчдын эсрэг хувийн эсэргүүцлийн арга хэмжээ авчээ. Энгэртээ бяцхан хүүгээ тэвэрсэн тэрбээр эсэргүүцлийн шалтгааныг тайлбарласан зурагт хуудас барин Хотын гүйцэтгэх хорооны шатан дээр 40-өөд минут зогссон байна.

“Цагдан хяналтаас ангид” үзэсгэлэн Ташкент 2001.06.18

Узбекийн “Ташкентын үнэн” сонины редакцид байнгын ажиллагаатай “Цагдан хяналтаас ангид” үзэсгэлэн нээгджээ. Үүнд Узбекийн цензурийн газраас хуулбарласан сонин, сэтгүүлчийн материалууд тавигдсан байна. Материалуудыг хоёр ам.дөрвөлжин талбай эзлэх хоёр лангуун дээр байрлуулсан аж. Мөн өдрийн орой нь үзэсгэлэн зохион байгуулагчид “Энэ лангууг хоёр дахин ихэсгэсэн ч болохоор байлаа” хэмээн мэдэгджээ.

Анх үзэсгэлэнг зөвхөн “Ташкентын үнэн” сонины материалаар бүрдүүлэн гаргах бодолтой байсан ч тус улсын Сэтгүүлчдийн байгууллагуудын анхаарлыг татсанаар цугласан материал нь анх төлөвлөж байсан хэмжээнээс хэдийнэ давсан юм.

Сэтгүүлчдийн эсэргүүцлийн арга хэмжээ – 49 царс модны тарьц суулгажээ. Алматы, 2001.04.06

Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай хуульд эрс өөрчлөлт хийхийг шаашаасан парламентын 49 гишүүнд зориулж үг хэлэх эрх чөлөөг хамгаалах “Адил соз” сангийн

Олон нийтийн хүчирхийллийн бус арга хэмжээ болон кампанит аян зохион байгуулах нь иргэний нийгмийн тогтсон ойлголт билээ. Эсэргүүцлийн арга хэмжээ болон аян зохион байгуулах практик талыг нь авч үзвэл:

1. Өргөн дэвшүүлж байгаа асуудлаа урьдаар гүн гүнзгий судалж сайтар боловсруулсан байна. Тухайн сэдвээ сайн мэдэхгүйгээр ярьж хөөрөх, тэр тусмаа мэргэжилтнүүдтэй санал солилцоход бэрхшээлтэй. Тиймээс эсэргүүцлийн арга хэмжээг зохион байгуулахаас өмнө тухайн асуудлын талаар материал цуглуулан шинжээчидтэй үүнийг хэрхэн шийдвэрлэж болох арга замын талаар шинжээчидтэй хэлэлцэж, бусад улс оронд уг асуудлыг хэрхэн шийдсэн жишээг цуглуулах хэрэгтэй.

2. Тулгарч буй тухайн асуудлаа шийдвэрлэх албан ёсны бүхий л арга замыг ашиглах

3. Эсэргүүцлийн арга хэмжээ явуулах газар, цаг хугацааг урьдаас тооцож, сайтар судалсны үндсэн дээр сонгоно.

4. Эсэргүүцлийн арга хэмжээг зохион байгуулах газрыг илүү үр дүнд хүрч болохуйцаар тооцож сонгох хэрэгтэй гэж “Гринпис” байгууллага үзэж байна. “Эсэргүүцлийн объект” нь иргэдийн эсэргүүцэл, эгдүүцлийг бүрэн мэдэрч байх ёстой. Нөгөө талаас хүнд нөхцөлд эсэргүүцлийн арга хэмжээ зохион байгуулж байгаа тохиолдолд аюулгүйн дүрмийг бодолцох хэрэгтэй.

санаачилгаар тус хотын сэтгүүлчид 49 царс модны тарьц суулгажээ. Хуульд өөрчлөлт оруулах санал гаргасан Соёл мэдээлэл, олон нийтийн зөвшөөрлийн яамны сайд Алтынбек Сарсенбаевт карагача модны суулгацыг гардуулсан байна.

“Умид /Итгэл найдвар/ ерөнхий сонин гаргасан нь” Баку 2001.01.23

Хараат бус сонинуудыг хоморголон устгах бодлого баримталсны эсрэг Азербейджаны 30 сонин хамтран эсэргүүцлийн илэрхийллээ болгон “Умид” /Итгэл найдвар/ нэртэй ерөнхий сонин гаргажээ. Эсэргүүцлийн аяны лоозонг “Европын зөвлөлд туг манддаг шиг манай улсад сонин мандаг”, “Сонины цаасыг бүү идэгтүн”, “Улс үндэстэнг талх, сонин, цааснаас бүү ангижруул”, “Цаасыг бүү идэгтүн, Биднийг бүү зодогтун”, “Чөлөөт хэвлэлийн хөгжилд саад болж буй хүмүүсийг шийтгэж, хэвлэлд дарамт учруулж буйг эцэслэе” гэх зэргээр бичжээ. Хамтарсан сонинг 2001 оны нэгдүгээр сарын 23-нд нийтлэн гаргасан бөгөөд дараа нь түүнийг булшлах ёслол зохион байгуулсан байна.

Мурманск мужийн сэтгүүлчид Владимир Жириновскийн эсрэг бойкот зарлав Мурманск, 2000.03.31

Мурманск мужийн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэсэг төлөөлөгч Владимир Жириновскийн намын эсрэг бойкот зарлахыг бүсийн сэтгүүлчдэдээ уриалжээ. Тэд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн төлөөлөгчидтэй харьцахдаа зүй бус авир гаргадаг Төрийн думын дэд даргын овилгогүй харьцаанд эгдүүцэж байгаагаа мэдэгдсэн юм. Владимир Жириновский “НТВ” телевизийн сэтгүүлч Елена Масюкийг дайрч доромжилсон, мөн Либерал Ардчилсан намын гишүүд хотын залуу сэтгүүлчийг машинд суугаа удирдагч руугаа хүчээр түлхсэн зэрэг тохиолдлыг сэтгүүлчид уг мэдэгдэлдээ иш татжээ. Үүнээс гадна Жириновскийн Мурманск мужид хийж буй айлчлалыг сурвалжлах үеэр Ардчилсан Либерал намын төлөөлөгч сэтгүүлчид мөнгө санал болгож сурвалжлагыг өөрийн сонирхолд нийцүүлэхийг оролдож байгаа бичлэгийг “ОРТ” телевиз Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнөхөн цацсан юм.



Тухайлбал, үйл ажиллагааг нь эсэргүүцэж буй объектын ажлын цагийн хуваарь, арга хэмжээнд оролцогчдын байршил, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, явган зорчигч гэх мэт хүчин зүйлийг харгалзана.

5. Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн анхаарлыг татах, эсэргүүцлийн арга хэмжээ болон тухайн өргөн тавьсан асуудал, түүнийг шийдвэрлэхэд чиглэсэн эсэргүүцлийн арга хэмжээний талаар сэтгүүлчид урьдаас мэдэж байх нь чухал. Мэдээллийг түгээх нь тухайн асуудлыг шийдвэрлэх үр нөлөөтэй хөшүүрэг болдог. Энэ тохиолдолд хэвлэлийн мэдэгдэл, шаардагдах баримт бичгийг хувилж бэлтгэсэн байвал зохино.

6. Олон нийтийн байгууллагын төлөөлөгчидтэй хамтран ажиллах, мэдээлэл цуглуулах, боловсруулах, бэлтгэх, хэрэгжүүлэх, гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавихад орон нутгийн олон нийтийн байгууллага, эсвэл тухайн асуудлаар сэтгэл дундуур явдаг хүмүүстэй нягт хамтран ажиллах нь зүйтэй.

Эх сурвалж: Онцгой нөхцөл дэх сэтгүүлчдийн төв,
“Хүчирхийллийн бус идэвхтэй үйл ажиллагаа”
“Олон нийтийн эсэргүүцлийн арга хэмжээг хэрхэн
зөв зохион байгуулах вэ?” 2003

Бэлтгэсэн: Г.Нарангарав